



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны есдүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эцэг эхчүүдээс хандивласан нийт 11,036,500.00 (арван нэгэн сая гучин зургаан мянга таван зуун) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэг (Б.Долгормаа)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэг (Б.Долгормаа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150591023

Нийслэлийн Өмчийн Хариуцааны газрын даргын
 2024 оны 09 дүгээр сарын 29-ны
 өдрийн /29/ тоот тушаалын хавсралт



Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 112 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Эх үүсвэр
						Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1.Тавилга эд хогшил								
1	Дрож цайвар	2024	сайн	м	13.5	204,000.00	2,754,000.00	Эцэг эхчүүд хандив
2	Нарийн дрож	2024	сайн	м	6	74,500.00	447,000.00	
3	Хивс улаан эрээн	2024	сайн	ш	1	850,000.00	850,000.00	
4	Дрож цайвар саарал	2024	сайн	м	15	100,000.00	1,500,000.00	
5	Хивс /шаргал эрээн/	2024	сайн	м	15.3	135,000.00	2,065,500.00	
6	Хивсэнцэр /шаргал/	2024	сайн	м	18	190,000.00	3,420,000.00	
Тавилга эд хогшлын дүн							11,036,500.00	
Бүртгэх хөрөнгийн нийт дүн							11,036,500.00	